

**“ГАРЫН ТАВАН ХУРУУ” ЖҮЖГИЙН  
СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ**

Ван Мандуга

**Агуулгын товч.** Тус өгүүлэлд Монгол улсын Төрийн хошой шагналт зохиолч Ч.Лодойдамбын “Гарын таван хуруу” жүжгийн гол агуулга, утга санаа, нийгмийн үйлдэл зэрэг талаар нарийн шинжлэл хийж, тус жүжгийн сурган хүмүүжүүлэх ач холбогдлын тухай өөрийн үзэлтээ дэвшүүлжээ.

Монгол улсын Төрийн хошой шагналт зохиолч Ч.Лодойдамбын 1966 онд зохиож Улсын драмын театрт Ардын жүжигчин, эрдэмтэн зохиолч Э.Оюуны найруулж тавьсан “Гарын таван хуруу” жүжиг бол ураг хурим, гэр бүлийн асуудлыг хөндсөн ёс суртахууны сэдэвт жүжиг юм. Тус жүжигт гэр бүлийн харьцаа, хүүхдийн хувь заяаны маш нарийн эгзэгтэй асуудлыг нийгмийн агуулгатай нягт холбон, уран сайхны төгс боловсорсон хэлбэрээр гаргасан учраас урлагийн газруудад байнга тоглодог жүжиг болсон бөгөөд үзэгч олны сонирхол, талархлыг маш ихээр татсан. 1983 онд оператор Балжинням, судлагч Нямдаваа хоёр тэгш эрхтэй найруулагч буюу ерөнхий оператороор хамтран ажиллаж уран сайхны кино болгон үйлдэж, мөнгөн хөшгөнд гаргаснаар тус жүжгийн нэр хүнд, нийгмийн үр нөлөөг нэн өндөр болгосон юм. Хожим нь тус кино Москвад болсон Олон улсын киноны их наадмын тусгай шагналыг хүртсэн байна (Долгорсүрэн Ц. 1986:41).

**Нэг. Жүжгийн товч агуулга**

Нягтлан бодогч бүсгүй Должинтой “Тоонотой гэрт толгой холбож, тостой тогоонд хошуу холбож” арваад жил хамт амьдарч, таван хүүхдийн эцэг болсон өндөр цалин авдаг инженер Шагдар нь бэлэвсэн залуу бүсгүй Хорлоотой хайр сэтгэлтэй болж нууц амраг бололцов. Шагдар шинэ хайр гэдгийн эрхэнд татагдаж, хувийн жаргал цэнгэлийн хойноос хөөцөлдөх болж, эхнэр Должин болон таван хүүхдээ өөрийнхөө сэтгэлийн цэнгэл эдлэхэд саад тотгор болж байна гэж ад үзэж голох болжээ. Таван хүүхдээн бодооч гэж эхнэр Должин нь хэчнээн ятган хориглосон ч тус болсонгүй. Шагдар эцэстээн өвчтэй эхнэр болон таван хүүхдээ орхиод залуу бүсгүй Хорлоотой нийлэн суужээ. Гэр бүл салж сарнин үр хүүхэд өнчрөн хохирох гунигт хувь тавилан энэ гэр бүлд тохиолдов. “Цасан дээр хяруу нэмнэ” гэдгээр удалгүй Должин өвчнөөр нас барав. Хөөрхий таван хүүхэд эцэгтээ хаягдаж, эхээсээ хагацаж түшиг тулгуураа алдан өнчрөн хоцорчээ.

Арван долоотой том охин Сүрэнгийн мөрөн дээр бага балчир Бат, Баяр, Элбэг, Идэр дөрвөн дүүгээ тэжээн өсгөж, хүмүүжүүлэн сургах хүнд үүрэг зайлахын аргагүй тавигдав. Сүрэн охин эцэгтээ хаягдсан гомдол хорсол, эхээс өнчин салсан гуниг зовнилын зөрчилт сэтгэлийг өвөрлөн, амьдралд тулгарсан ядуу зүдүү, өнчин өрөөсөн, гачигдал зовлон, хатуу бэрх бүхнийг даван туулах сэтгэлийн тэнхээгээр дүү нараа өсгөн бойжуулж, хүмүүжүүлэн сургах хүнд үүргийг зоригтойгоор үүрэглэн авчээ.

Сүрэн сургуулиасаа гарч нэхмэлийн үйлдвэрийн ажилчин болж, дүү нараа тэжээх болов. Тэрээр дүү нартаа өлсөх даарахын зовлонг үзүүлээгүй бөгөөд хүнлэг сэтгэлтэй, ажилсаг шударга хүмүүс болгон өсгөжээ. Таван хүүхдийн амьдрал хэдийгээр хүнд хэцүү байсан боловч гарын таван хуруу шиг сэтгэл нэгтэй чармайн тэмцэж, улс гэрийн тусламж, халуун сэтгэлт хүмүүсийн ач тусаар тулгарсан бэрхшээлийг даван туулж, улс нийгэмдээ тустай хүн болж өсөж өндийв. Сүрэн шилдэг ажилчин, Хувьсгалт залуучуудын эвлэлийн төлөөлөгчөөр сонгогдож, түүний тэргүүний үйл ажиллагааг нь сонинд нийтлэн сурталчилж байна. Их дүү Бат нь сурлагын амжилтаараа их сургууль төгсөн үнэмлэх гардаж ажилд орж байна. Удаах дүү Баяр нь амьдралын эрхээр сурлага зогсож, шороо түлхэх машины тэргүүний жолооч болж, улмаар сэтгэлийн амраг Оюунтайгаа хамт Дархан хотод ажиллахаар явж байна. Хоёр бага дүү Элбэг, Идэр хоёр нь хичээл сурлагадаа мэрийж ёс моральтай, шулуун цайлган сэтгэлтэй, шударга хөдөлмөрч зан чанартай хүн болж хүмүүжиж байна. Шагдарт хаягдсан таван хүүхэд өөрсдийнхөө зүтгэл чармайлтаар “эр өсөж эсгий сунадаг” гэх ёсоор “Энэ өдөр бидэнд сайханд байна” гэх хүний сэтгэлийг хөдөлгөм сайн үр дүнд хүрч чадсан байна.

### **Хоёр. Жүжгийн гол утга санаа**

“Гарын таван хуруу” жүжигт шинэ хайр дурлал гэдгийн хойноос хөөцөлдөж, арваад жил хамт амьдарсан эхнэр Должин, гарын таван хуруу шиг таван хүүхдээ хаяж явсан инженер Шагдарын хүн чанар, хүнлэг ёс, ёс суртахуунаас гажсан үзэл бодол, үйл ажиллагааг жигшин буруушааж, гэр бүл салж сарнин, үр хүүхэд өнчрөн хоцорч бие сэтгэлийн гашуун зовлонг цадтал эдэлсэн нэг хэлхээ үйл явдлыг амьдлаг бодитой дүрслэн тусгахаар дамжуулж гэр бүл салж сарнин, үр хүүхдээ өнчрүүлэхийг шүүмжилсэн гол утга санааг гаргажээ. *“Лодой жүжигтээ хүүхдийнхээ төлөө өөрийгөө хохироох нь юу ч бус. Шагдар шиг ганц хар амиа бодож хүүхдүүдийг бүү хохироо гэж хэлэх гэсэн юм”* гэж Ц.Долгорсүрэнгийн (1986:41) хэлсэн үг бол яг тус жүжгээс ургаж гарах гол санаа юм.

Энэ жүжигт алдаж боломгүй хайр сэтгэлдээ татагдан өөр хүнтэй яах аргагүй ханилахад хүргэх “Нийгмийн энэхүү нуугдмал чанарыг Лодойдамба зохиолч санаатай санаагүй алин боловч гаргаж тавьсан, Шагдар хэмээх өөрийн онцгой дүр төрхтэй зан төрхийг бүтээж чадсан” (Байгалсайхан С. 1998:56) тэр алхам нь хувь хүнийх нь хувьд зөв боловч “Харин нийгмийн өмнө хүлээсэн үүргийн өмнө буруутай. Тэрээр таван хүүхдээ халамжлан гарыг нь ганзганд хөлийг нь дөрөөнд хүргэх эцэг хүний үүргээ биелүүлэх ёстой. Энд нийгэм, хувь хүн хоёрын хооронд зөрчил гардаг” (Байгалсайхан С. 1998:56). Энэ жүжгийн тэрхүү нийгмийн өмнө, үр хүүхдийнхээ өмнө хүлээх үүрэг ёс зүй, хүнлэг чанарыг өнөөдөр эргэж ярих, бараг өнөөгийн уран бүтээлээс эргэж нэхэх учир бас байна.

Тус жүжигт гарах “хүн чанар” гэх дүрийн тухай өнгөрсний судлагчид хувь хувийн үзэлтээ дурдаж энэ дүрийн жүжигт үзүүлэх үйлдлийг “Шагдарын дүрийн эсрэг хүн чанар гэсэн сонин дүрийг сөргүүлэн тавьж хүнлэг чанар, ёс суртахуун, гэр бүлийн асуудлыг нийгмийн шинж төлөвтэй нарийн нягт холбож чадсан байна” (Дугарсүрэн Т. 1986:182). “Энэ жүжгийн үзэгдлүүдийн завсраар хүн чанар гэдэг дүр гарч Шагдартай ярилцаж буйгаар зохиомжилсон нь сонирхолтойгоос гадна олон саланги хэсгүүдийг нэгтгэж өгчээ. Ингэж хүн чанар Шагдарыг буруушаан зэмлэж байх нь жүжгээс нэвтрэн гарах санаа юм” (Хөвсгөл С.) гэх мэтчилэн тодорхойлон өгүүлжээ. Эдгээр үзэлт хүн чанар гэх дүрийн тухай нэлээд зөв зүйтэй дүн шинжилгээ хийсэн гэж үзэж болно.

Миний үзэхээр хүн чанарын дүр бол хэрэг дээрээ зохиогчийн биеийн төлөөний дүр юм. Зохиогч өөрийн гол үзэл бодол, хэлэх гэсэн үг, гаргах гэсэн санаагаа хүн чанарын үг яриагаар илтгэн гаргасан хэрэг. Энэ уламжлал Монгол уран зохиолын түүхэнд бий. Жишээлбэл, их зохиолч Инжиннааши “Нэг давхар асар”, “Улаанаа ухилах танхим” романдаа зохиолынхоо баатрын харилцан яриагаар шүлэг зохиолын тухай өөрийн үзэл онолоо илтгэж

байжээ. “Билиг төрөгдөхүйд онц чухам хэрэгт тохиолдсон хойно сая онож чадмуй”, “Шүлэг найруулахуйд хэдий далдаас бичиж болох боловч өнгө чанарт нэвтрэхүй нь эгнэгт дэргэд нь хүрэхүйд хүрэх үгүй”, “Шүлэг зохиох хэдий өчүүхэн хэрэг боловч нэгэн үг хагас бадагт хүн биеийн үйлийг мэдвээс болмуй” гэх мэт урлаг утга зохиолын тухай олон сайхан үзэл онолоо бүр зохиолын баатрын яриагаар илтгэсэн байдаг.

### **Гурав. Жүжгийн сурган хүмүүжүүлэх одоохич ач холбогдол**

Улс нийгмийн хамгийн үндсэн жижиг нэгж болсон гэр бүлийн тухай асуудлыг аль ч нийгэмд чухалчлагдан байдаг боловч тухайн нийгмийн мөн чанар, агуулгатай салшгүй холбоо уялдаатай байдаг. “Тэгэхдээ гэр бүлийн харьцаа нь хайр сэтгэлийн нарийн шижмээр холбогдсон хувь хүний хоорондын сайн дурын шинжтэй боловч хүмүүсийн ёс суртахууны шинж чанарыг илэрхийлж байгаагаараа нийгмийн бусад харьцаануудаас ялгаатай бөгөөд янз бүрийн зөрчил үүсч байдаг” (Дугарсүрэн Т. 1986:180).

Зохиогч Ч.Лодойдамба бээр гэр бүл салах явдал ердийн үзэгдэл болж, хүүхэд өнчрөн хохирох явдал элбэг болж байсан тухайн нийгмийн сөргүү үзэгдэлтэй холбогдуулан Шагдар, Должин хоёрын энэх онцгой байдалтай гэр бүлээр нийтлэг жишээ болгон тус жүжгээ сэдэвлэн бичжээ. Юунд онцгой байдалтай вэ гэвэл, Шагдар, Должин хоёр бол ураглаад арван хэдэн жил болсон, таван хүүхэд төрүүлсэн, удаан жил жаргал зовлонгоо хамтатгаж, зан зангаа мэдэлцэж, хамт амьдарсан заяа нэгтэй эр эм хоёр. Харин хуримлаад удаагүй зан зангаа арай ололцоогүй шинэхэн хос биш. Иймэрхүү удаан жил хамт амьдарч олон хүүхдийн эцэг эх болсон гэр бүл онцын нөхцөл шалтгаангүйгээр салж бутарна гэдэг бол онцгой үзэгдэл. Шагдар шиг ийм насны дээд боловсрол хүртсэн хүн шинэ хайр дурлал гэдэгт эргүүтэж, хуучнаан голж шинэд дурлаж, өвчтэй эхнэр, балчир бага таван хүүхдээ орхиод, хар амины сэтгэлийн цэнгэл эдэлнэ гэж явах нь мөн онцгой үзэгдэл. Тэр мөртлөө хүн чанар, хүнлэг ёс, нийгмийн ёс суртахуунаас зөрчсөн жигшүүртэй үйл ажиллагаа болох юм.

Тэгэхлээр жүжгийн баатар Шагдар олон хүнд жигшигдэж, шүүмжлэгдэж байдаг. Жишээ нь, Должиноос “Чи бол таван хүүхдийн жаргалыг эвдэж байгаа хүн... Би Хоролмааг зэмлэхгүй ээ, нөхөр нь нас барсан, нялх хүүхэдтэй, ганц бие эмэгтэй ханьтай больё гэж бодохгүй яахав. Харин ардаа таван хүүхэдтэй байж ингэж явдаг чамайг л бол жигшинэ. Түүгээр барахгүй хүүхдүүд чинь чамд гомдоно, чамайг жигших болох байх даа” (Лодойдамба Ч. 1977) гэж хэлсэн бөгөөд нас барахаасаа өмнө хүүхдүүддээ: “...Шагдарыг битгий царайчлаарай” (Лодойдамба Ч. 1977) гэсэн гэрээс үлдээсэн байдаг. Должинг оршуулах үед Шагдарт хэлсэн байтал ажилдаа шалтагчилж ирсэнгүй. Хамт ажиллагсад нь Шагдарыг ам амандаа зэмлэж байна. Хамт суусан Хорлоо хүртэл “Хүний үнэргүй муухай амьтан” (Лодойдамба Ч. 1977) гэж хэлсэн байна. Сүрэн дүү нартаа “Аав гэнэ ээ. Аав юм бол яагаад биднийг татаж дууссан тамхины иш шигээ шидээд явчихсан юм бэ... Тийм аав байснаас байхгүй нь дээр гэж чамд олон хэлсэн шүү дээ” (Лодойдамба Ч. 1977) гэж хэлсэн бөгөөд дөрвөн дүүтэйгээ хамт Шагдарыг эцгээ гэж үзэхгүй болж эцэг хүүхдийн харьцаагаа тасалж хаяад шууд Шагдар гэж нэрлэн дуудах болсон байна. Сүрэн янаглаж байгаа залуу Чулуунд “Гоё үгийг хэн ч хэлж чаддаг юм. Гэхдээ чиний нүүрэн дээр ирээдүйн Шагдар биш гэсэн баталгаа үгүй байна. Ээжтэй минь анх суухдаан лав чамаас гоё үг хэлж байсан байх даа” (Лодойдамба Ч. 1977), “Би нэг үе инээж байгаа хүнийг харахаар л энэ юу бодож байгаа бол, Шагдар ингэж инээж байсан шүү гэж боддог байсан...” (Лодойдамба Ч. 1977) гэж хэлж байна.

Хорлоогийн арван гурван настай охин Гэрлээ Шагдарыг таван хүүхдээ өнчрүүлсэн муу аав гэж жигшээд, аав гэж дуудахыг байтугай ах гэж ч дууддаггүй, шууд Шагдар гуай гэж байна. Бас ээждээ “Нас барсан болохоос биш би аавтай хүн шүү дээ... Хаяж явсан муу аавтай байсан бол би сайн аавтай болохсон гэж бодох байхсан. Тэгээд олбол баярлах л байхсан” (Лодойдамба Ч. 1977), “Би тэр таван хүүхдийг аавгүй болсон гэж бодохоор л өрөвдөөд

байна. Аавгүй байх хэцүү шүү дээ, тийм үү” (Лодойдамба Ч. 1977) гэж зүрх шимшрэм ярьж байна. Тэр мөртөө аавынхаа хуучин зангиаг ч Шагдарт зүүлгэх дургүй, зангиаг нь аваад цаад тасалгаа руу гүйн орж байна.

“Шинэ хайр сэтгэлийнхээ эрхшээлд автан таван хүүхдээ өнчрүүлсэн Шагдарыг төрсөн хүүхдүүд нь эцгээ гэж үзэхээ больсоноор яллажээ. Төрсөн үрс нь эцгээ гэж үзэхээ болихоос илүү шийтгэл эцэг хүний хувьд байхгүй нь илэрхий” (Долгорсүрэн Ц. 1986:39). Тийм ч учраас Шагдар асар их сэтгэлийн хямралд орж “Тэгээд би хэний эцэг юм. Гэрлээ намайг ах ч гэдэггүй шүү дээ. Өөрийнх ч үгүй, өрөөлийн ч үгүй зайлж зугтаасан яасан энэрэлгүй хорвоо вэ” (Лодойдамба Ч. 1977) гэж гомдол мэдүүлж байна.

Энэ бол энэрэлгүй хорвоогийн гай биш, гэрээс үг үлдээж “хатуу сэтгэл гаргасан” Должины ч буруу биш, харин Шагдарын өөрөө үйлдсэн хүн чанараа алдсан нийгмийн ёс суртахуунаас гажсан сөргүү үйл явдлынх нь зайлшгүй үр дагавар болно. Энэ бол нийгмийн ёс суртахууны шүүх танхимаас шүүн тасалсан эцсийн шийтгэл мөн.

“Гарын таван хуруу” жүжигт хүмүүсийг амьдралд ухаалаг хандахыг сургамжилсан төдийгүй ёс суртахууны эмзэг нарийн асуудлыг дэлгэрэнгүй тавьснаараа үзэгчдэд ихийг бодогдуулах сурган хүмүүжүүлэх чадалтай болжээ. Жүжиг театрт тавигдсанаас нааш, ялангуяа кино болж мөнгөн хөшигт гарч дэлхий нийтэд цацагдсанаас нааш үзэгч олны урлагийн хүртээл болж, сэтгэлийн гүнд хүрч, нийгэмд гүйцэтгэх танин мэдүүлэх, сурган хүмүүжүүлэх, гоо таашаалын хавь цэнгэлийн үйлдлээ үзүүлсээр иржээ. Энэ жүжиг нь хүмүүсийн юуг үнэн сайн сайхан гэж үзэх, юуг худал муу муухай гэж үзэх гоо зүйн үзэлтэд чухал ач холбогдолтой байсан бөгөөд энэ өдөр ч гэсэн сурган хүмүүжүүлэх одоохич ач холбогдлоо алдаагүй байна.

Хүн төрөлхөтний нийгэм XXI зуунд давшин орж, даяарчлах алхац улам түргэсэж байгаа энэ өдөр нийгмийн улс төр, эдийн засаг, соёл шинжлэх ухаан нэн түргэн хурдацаар урагш хөгжиж байна. Үүнийг дагалдан нийгмийн харилцаа, гэр бүлийн амьдралд ч маш их хувиралт гарч байна. Харь соёлын нөлөө, хүний эрхийн үзэлт, өртөгийн үзэлтийн хувьсал, янаг дурлал, ураг хурим, гэр бүлийн тухай үндсэн үзэлт зэрэгт ч тодорхой хэмжээний хувиралт гарч байна.

Энэ байдалд дэлхийн аль улс орны хүрээнд нийгмийн харьцаа, ураг хурим, гэр бүлийн асуудлын талаар нэн олон нарийн эгзэгтэй асуудлууд буй болов. Дундад улсаар жишээлэхэд ураг салж, гэр бүл бутарч, хүүхэд өнчрөх үзэгдэл жилээс жил олшрон нэмэгдэж нийгмийн том чухал асуудал болж байна. Эдгээр асуудлыг дан ганц засаг захиргааны арга буюу хууль зүйн үүднээс шийдвэрлэж болохгүй. Ихэнхийг нь хувь хүний ухамсар, ёс суртахуун, үзэл санааны түвшинг дээшлүүлж, сурган хүмүүжилд түшиглэн шийдвэрлэх хэрэгтэй. Иймээс “Гарын таван хуруу” жүжиг шиг сурган хүмүүжүүлэх ач холбогдолтой урлагийн бүтээлийг нэн илүү шаардах болж байна.

Доор Дундад улсын ураг гэр бүл салж байгаа тухай хэдэн хувь, тоо бүртгэлийг хүснэгтээр сийрүүлэн үзүүлье.

1. Энэ бол бүх Дундад улсын 2012 оноос 2017 он хүртэлх жил тус бүрийн урагласан тоо ба ураг салсан тоо бүртгэлийн хүснэгт болно. (Эрдэм судлал Дундад улс, 2017)

| Он                     | Урагласан тоо | Ураг салсан тоо |
|------------------------|---------------|-----------------|
| 2012                   | 6431486       | 1112197         |
| 2013                   | 7079916       | 1342943         |
| 2014                   | 6940306       | 1455005         |
| 2015                   | 6207239       | 1516236         |
| 2016                   | 6043386       | 1683068         |
| 2017 /эхний хагас жил/ | 5584953       | 1855876         |

(Дундад улсын Худалдаа үйлдвэрлэл судлах хүрээлэнгийн бүртгэсэн тоо баримт)

2017 оны эхний хагас жилд 5 сая 584 мянган хос шинэ гэр бүл болж, түүнээс 1 сая 855 мянга нь салжээ. Энэ гэр бүл салсан тоо хэмжээгээр хамаг өндөр нь Бээжин, Шанхай, Шэнжин, Гуанжу зэрэг хот болно.

1. Ураг салсан тоо хэмжээгээр хамаг их 10 хотыг хүснэгтээр үзүүлвэл:

|                |         |
|----------------|---------|
| Бээжин         | 39%     |
| Шанхай         | 38%     |
| Шэнжин         | 36, 25% |
| Гуанжу         | 35%     |
| Шамин          | 34, 9%  |
| Тайби          | 34, 8%  |
| Хонгог/Гонког/ | 33, 8%  |
| Даалин         | 31%     |
| Ханжуо         | 29%     |
| Харбин         | 28%     |

3. Доорх бол 1980 он, 1990 он, 2000 он, 2010 он тус бүрийн бүх улсын ураг салсан тоог бүртгэсэн хүснэгт болно. (Эрдэм судлал Дундад улс, 2017)

| Он      | Ураг салсан тоо |
|---------|-----------------|
| 1980 он | 341 мянга       |
| 1990 он | 800 мянга       |
| 2000 он | 1 сая 210 мянга |
| 2010 он | 2 сая 670 мянга |

(Дундад улсын Худалдаа үйлдвэрлэл судлах хүрээлэнгийн бүртгэсэн тоо баримт)

Бүх улсын ураг салсан тоо 30 жилд 8 дахин нэмэгдэв.

4. Доорх бол 2014 – 2016 оны жил тус бүрт шүүн тасалсан ураг салсан хэргийн тоо бүртгэл болно (Эрдэм судлал Дундад улс, 2017).

| Он                        | Ураг салсан тоо | Тодорхойлолт                                   |
|---------------------------|-----------------|------------------------------------------------|
| 2014 он                   | 1 сая 120 мянга |                                                |
| 2015 он                   | 1 сая 200 мянга |                                                |
| 2016 оны 1-9-р сар хүртэл | 1 сая 040 мянга | 2015 оны адил хугацаанаас 10, 8 %-иар нэмэгдэв |

(Дундад улсын Худалдаа үйлдвэрлэл судлах хүрээлэнгийн бүртгэсэн тоо баримт)

5. 2016 онд Дундад улсын ураг салсан нийт тоо 4 сая 200 мянгад хүрч 2015 оны үеэс 8, 3% хувиар нэмэгдлээ” (Бүх дэлхийн цагийн байдал, 2017:6) гэж “Бүх дэлхийн цагийн байдал” сонин дээр мэдээлжээ .

Ураг салж байгаа гол шалтгаан нь доорх мэт:

- (1) Эр эм хоёр харилцан хайр сэтгэл байхгүй болсноос ураг салж байгааг 45, 9%;
- (2) Гэр бүлийн хүчирхийллээс болж ураг салж байгаа нь 27, 8%;
- (3) Аль нэг нь гэр бүлийн амьдралаа зөрчсөнөөс болж ураг салж байгаа;
- (4) Хувь хүний тогтсон гаж зангаас болж ураг салж байгаа.

Голдуу ийм 4 зүйлийн шалтгаанаас гэр бүл салж байна гэж үзжээ. Бүх улсын ураг салсан зууралдааны дотор 96 хувь нь үр хүүхдийн тэжээж асрахад холбогдсон асуудал болно (Эрдэм судлал Дундад улс, 2017).

Ураг салах иргэний хэргийг шүүн тасалсан үр дүнг үзвэл бүх улсын ураг салах зууралдааны 63%-ийг гэр бүлийн харьцаагаа үргэлжлүүлж байхаар шүүн тасалсан байдаг (Эрдэм судлал Дундад улс, 2017).<sup>1</sup>

Дундад улсын зүүн хэсгийн зарим муж орнуудаар ийм нэг шинэ дүрэм тогтоон хэрэгжүүлж байна: Ураг салахаар шүүхэд бичиг өгсөн эр эм хоёр эрхбиш 3 сарын хугацааны тайвшралын шатыг хүлээх хэрэгтэй, тайвшралын шатыг дуусахаас 7 хоногийн өмнө хоёр талаараа бодит байдлаа үндэслэж шүүхэд өргөдөл гаргаж тайвшралын хугацааг урагшлуулах буюу сунгах тухай саналаа дурдах ёстой. Энэ үндсэн дээр шүүх хороо сая ураг салах шүүн таслалт хийж байна гэж “Бүх дэлхийн цагийн байдал” сонин дээр мэдээлжээ<sup>2</sup>.

Ийм учраас энэ цаг үед гэр бүлийн тогтвортой амьдрах асуудлыг дан ганц засаг захиргааны арга буюу хууль зүйн үүднээс шийдвэрлэж болохгүй. Ихэнхи нь хувь хүний ухамсар, ёс суртахуун, энэрэнгүй үзэл, үр хүүхдээ хайрлах үзэл төлөвшлийг хувь хүнд өгөх “Гарын таван хуруу” жүжиг шиг сурган хүмүүжүүлэх, хүний ёс зүйн төлөвшилд ач холбогдолтой урлагийн бүтээлийг нэн илүү шаардах болж байна.

### Номзүй

- Байгалсайхан С.** 1998. *Уран дүрийн онолын лекцүүд*. Уб.
- Долгорсүрэн Ц.** 1986. *Ч.Лодойдамбын тухай дурсамж*. Уб.
- Дугарсүрэн Т.** 1986. *Ч.Лодойдамбын жүжгийн зохиолууд*. Хэл зохиол судлал. Уб., XVII боть.
- Хөвсгөл С.** *XX зууны Монголын жүжиг*. Машиндмал эх.
- Лодойдамба Ч.** 1977. Түүвэр зохиол. *Гарын таван хуруу*. Уб.
- Монголын орчин үеийн уран зохиолын түүх*. III боть. 1998. Уб.,
- “Эрдэм судлал Дундад улс” сүлжээ. 2017 оны 10-р сарын 05-ны өдрийн мэдээлэл.
- “Бүх дэлхийн цагийн байдал” сонин. М. 4325-р номер. 2017. 10. 27-ны өдрийн сонин.

---

<sup>1</sup> “Эрдэм судлал Дундад улс” сүлжээ, 2017 оны 10-р сарын 05-ны өдрийн мэдээлэл. Тоо баримтын эх сурвалж: Дээд зэргийн шүүх хорооны их тоо баримтыг хамаарах болоод үйлчлэх тавцан. Бүртгэлийн хугацаа: 2014 оны 1-р сарын 1-ний өдрөөс 2016 оны 9-р сарын 30-ны өдөр хүртэл. Тоо баримтын хүрээ хэвцээ: Иргэний хэргийг шүүн таслах нэгдүгээр тэнхмээс шүүн тасалсан хэргүүд. Үйлдсэн цаг: 2016 оны 11-р сар.

<sup>2</sup> “Бүх дэлхийн цагийн байдал” сонин. 4325-р номер, 2017, 10, 27-ны өдрийн сонины 6-р нүүр. “Ураг салахад тайвшралын шат үеийг өнгөрүүлэх үү” гэх мэдээ.